

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Архивын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/604/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn Санхүү-Нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: С.Гантөгс Утас: 325093 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Цолмон Утас: 325093 Цахим хаяг: Tsolmonba@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025-08-05 № 201
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН АРХИВЫН
ГАЗРЫН ДАРГА Х.ГАНТУЛГА
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Архивын газрын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 173.6 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд лавлагаа мэдээллийн орлого 40.2 сая төгрөг, хэвлэх цехийн орлого 341.8 сая төгрөг нийт 382.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, орон нутгийн төсөвт 251.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Улсын үзлэг зохион байгуулах тухай" А/1220 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн хэмжээнд "Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг" зохион байгуулахад 260 албан хаагч оролцож, 1510 байгууллагад тус үзлэгийг зохион байгуулж ажилласан байна.

1426050259

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 55 зорилтын хүрээнд 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	83,882,368.60	67,030,128.16
33	АВЛАГА	-	90,832.76
335	Бусад авлага	-	90,832.76
3351	Байгууллагаас авах авлага	-	90,832.76
35	БАРАА МАТЕРИАЛ	83,882,368.60	66,939,295.40
354	Хангамжийн материал	83,882,368.60	66,939,295.40
35410	Бичиг хэргийн материал	13,563,210.00	20,837,770.00
35420	Аж ахуйн материал	39,879,496.60	21,182,277.40
35470	Бусад хангамжийн материал	30,439,662.00	24,919,248.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	717,194,056.16	977,455,661.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	717,194,056.16	977,455,661.26
392	Биет хөрөнгө	578,512,916.16	839,299,521.26
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	619,913,422.53	868,653,722.53
39206	Хуримтлагдсан элэгдэл	(177,600,107.03)	(318,530,328.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	211,597,462.58	397,846,262.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	(75,397,861.92)	(108,670,135.34)
393	Биет бус хөрөнгө	138,681,140.00	138,156,140.00
39301	Програм хангамж	261,538,105.00	261,538,105.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(260,575,605.00)	(261,100,605.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	137,718,640.00	137,718,640.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	801,076,424.76	1,044,485,789.42
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	801,076,424.76	1,044,485,789.42
51	Засгийн газрын хувь оролцоо	801,076,424.76	1,044,485,789.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	212,660,646.93	212,660,646.93
51101	Өмч:- төрийн	212,660,646.93	212,660,646.93
512	Хуримтлагдсан үр дүн	586,604,883.40	830,014,248.06
51210	Өмнөх үеийн үр дүн	317,727,281.53	586,604,883.40
51220	Тайлант үеийн үр дүн	268,877,601.87	243,409,364.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,810,894.43	1,810,894.43

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	801,076,424.76	1,044,485,789.42
---	--	-----------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,787,906,431.98	3,667,530,121.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	483,400,083.44	522,044,038.21
120	Нийтлэг татварын бус орлого	483,400,083.44	522,044,038.21
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	483,400,083.44	522,044,038.21
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,641,600.00	40,290,584.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	174,635,692.00	211,502,954.21
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	279,122,791.44	270,250,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,304,506,348.54	3,145,486,083.77
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,128,380.91	168,925,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,128,380.91	2,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	157,425,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,291,377,967.63	2,976,561,083.77
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,291,377,967.63	2,976,561,083.77
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,518,974,883.44	3,424,120,757.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,518,974,883.44	3,424,120,757.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,496,698,231.44	3,115,592,424.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,737,792,689.37	1,979,442,338.53
210101	Үндсэн цалин	896,958,502.40	1,011,853,022.78
210102	Нэмэгдэл	360,053,767.00	366,107,653.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	280,662,602.00	425,720,152.34
210104	Урамшуулал	140,853,937.00	151,254,635.00
210105	Гэрээт ажлын хөлс	59,263,880.97	24,506,875.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	222,710,123.70	260,341,309.85
210201	Тэтгэврийн даатгал	155,998,529.73	176,723,992.59

Нийслэлийн Архивын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	17,316,211.00	20,475,038.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,434,965.85	13,705,180.74
210204	Ажилгүйдлийн даатгал	3,525,321.99	9,154,135.60
210205	Эрүүл мэндийн даатгал	33,435,095.13	40,282,962.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	261,462,946.00	307,218,952.00
210304	Байрны түрээс	261,462,946.00	307,218,952.00
2104	Хангамж, бараа материалын зардал	114,985,864.13	242,536,769.71
210401	Бичиг хэрэг	37,693,599.00	66,030,815.00
210402	Тээвэр, шатахуун	11,562,850.00	28,179,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,401,165.13	22,564,472.51
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,286,370.00	26,851,485.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,041,880.00	98,910,197.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,672,000.00	22,601,560.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,672,000.00	2,144,900.00
210604	Урсгал засвар	17,000,000.00	20,456,660.00
2107	Томилолт, зочны зардал	13,128,380.91	-
210701	Гадаад албан томилолт	13,128,380.91	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,834,831.00	56,709,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,965,020.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	60,520,000.00	56,709,000.00
210807	Газрын төлбөр	1,349,811.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,111,396.33	246,742,494.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	71,515,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,111,396.33	174,727,494.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,276,652.00	308,528,332.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,999,360.00	226,734,793.33
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	16,483,750.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	114,753,593.33
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,999,360.00	95,497,450.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,277,292.00	81,793,539.00

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,277,292.00	81,793,539.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>268,931,548.54</u>	<u>243,409,364.66</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	53,946.67	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	53,946.67	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(53,946.67)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>268,877,601.87</u>	<u>243,409,364.66</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,508,783,640.54</u>	<u>3,397,279,621.98</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	204,277,292.00	251,793,538.21
120	Нийтлэг татварын бус орлого	204,277,292.00	251,793,538.21
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	204,277,292.00	251,793,538.21
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,641,600.00	40,290,584.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	174,635,692.00	211,502,954.21
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,304,506,348.54	3,145,486,083.77
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,128,380.91	168,925,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,128,380.91	2,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	157,425,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,291,377,967.63	2,976,561,083.77
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,291,377,967.63	2,976,561,083.77
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,481,559,640.54</u>	<u>3,232,541,021.98</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,481,559,640.54	3,232,541,021.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,459,282,988.54	2,924,012,689.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,737,792,689.37	1,979,442,338.53
210101	Үндсэн цалин	886,340,228.40	1,011,853,022.78
210102	Нэмэгдэл	360,029,767.00	366,107,653.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	291,280,876.00	425,720,152.34
210104	Урамшуулал	140,853,937.00	151,254,635.00
210105	Гэрээт ажлын хөлс	59,287,880.97	24,506,875.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	222,710,124.13	260,432,142.61
210201	Тэтгэврийн даатгал	154,888,454.90	176,814,825.35
210202	Тэтгэмжийн даатгал	17,316,211.00	20,475,038.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,545,040.68	13,705,180.74
210204	Ажилгүйдлийн даатгал	3,389,093.17	9,887,419.91
210205	Эрүүл мэндийн даатгал	33,571,324.38	39,549,677.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	261,462,956.00	307,218,952.00
210304	Байрны түрээс	261,462,956.00	307,218,952.00
2104	Хангамж, бараа материалын зардал	100,522,059.13	191,948,696.51
210401	Бичиг хэрэг	44,959,010.00	71,219,845.00
210402	Тээвэр, шатахуун	11,562,850.00	28,179,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,336,365.13	22,564,472.51

Нийслэлийн Архивын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,286,370.00	26,851,485.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,377,464.00	43,133,094.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,757,100.00	30,294,560.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,757,100.00	6,688,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	3,149,500.00
210604	Урсгал засвар	17,000,000.00	20,456,660.00
2107	Томилолт, зочны зардал	13,128,380.91	-
210701	Гадаад албан томилолт	13,128,380.91	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	91,909,679.00	63,001,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,410,505.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	60,520,000.00	63,001,000.00
210807	Газрын төлбөр	2,979,174.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	91,675,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	91,175,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,276,652.00	308,528,332.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,999,360.00	226,734,793.33
213204	Ажил олгогчоос олгохбусад тэтгэмж, урамшуулал	-	15,015,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	114,753,593.33
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,999,360.00	96,966,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,277,292.00	81,793,539.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,277,292.00	81,793,539.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>27,224,000.00</u>	<u>164,738,600.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	35,219,000.00	164,738,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,219,000.00	164,738,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	35,219,000.00	164,738,600.00
223001	Бусад хөрөнгө	7,995,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,224,000.00	164,738,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(35,219,000.00)</u>	<u>(164,738,600.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(7,995,000.00)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,995,000.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	212,660,646.93	1,810,894.43	317,727,281.53	532,198,822.89
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,660,646.93	1,810,894.43	317,727,281.53	532,198,822.89
7	Тайлант үеийн үр дүн	-	-	268,877,601.87	268,877,601.87

Нийслэлийн Архивын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,660,646.93	1,810,894.43	586,604,883.40	801,076,424.76
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,660,646.93	1,810,894.43	586,604,883.40	801,076,424.76
16	Тайлант үеийн үр дүн	-	-	243,409,364.66	243,409,364.66
17	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,660,646.93	1,810,894.43	830,014,248.06	1,044,485,789.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,479,980,800.00	3,146,561,082.98	333,419,717.02	90.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,479,980,800.00	3,146,561,082.98	333,419,717.02	90.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,320,425,300.00	2,997,826,289.65	322,599,010.35	90.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,129,746,800.00	1,979,442,338.53	150,304,461.47	92.9
210101	Үндсэн цалин	1,017,413,500.00	1,011,853,022.78	5,560,477.22	99.5
210102	Нэмэгдэл	425,124,000.00	366,107,653.41	59,016,346.59	86.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	489,130,000.00	425,720,152.34	63,409,847.66	87.0
210104	Урамшуулал	174,927,600.00	151,254,635.00	23,672,965.00	86.5
210105	Гэрээт ажлын хөлс	23,151,700.00	24,506,875.00	(1,355,175.00)	105.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	275,439,900.00	260,432,142.61	15,007,757.39	94.6
210201	Тэтгэврийн даатгал	189,466,100.00	176,814,825.35	12,651,274.65	93.3
210202	Тэтгэмжийн даатгал	21,493,500.00	20,475,038.84	1,018,461.16	95.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,746,700.00	13,705,180.74	(2,958,480.74)	127.5
210204	Ажилгүйдлийн даатгал	10,746,700.00	9,887,419.91	859,280.09	92.0
210205	Эрүүл мэндийн даатгал	42,986,900.00	39,549,677.77	3,437,222.23	92.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	351,717,800.00	307,218,952.00	44,498,848.00	87.3
210304	Байрны түрээс	351,717,800.00	307,218,952.00	44,498,848.00	87.3
2104	Хангамж, бараа материалын зардал	211,455,800.00	173,198,696.51	38,257,103.49	81.9
210401	Бичиг хэрэг	86,141,500.00	71,219,845.00	14,921,655.00	82.7
210402	Тээвэр, шатахуун	16,512,000.00	9,429,800.00	7,082,200.00	57.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,992,800.00	22,564,472.51	1,428,327.49	94.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	35,804,500.00	26,851,485.00	8,953,015.00	75.0

Нийслэлийн Архивын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	49,005,000.00	43,133,094.00	5,871,906.00	88.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	259,058,000.00	195,033,160.00	64,024,840.00	75.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	141,020,000.00	104,627,000.00	36,393,000.00	74.2
210602	Тавилга	85,300,000.00	66,800,000.00	18,500,000.00	78.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,418,000.00	3,149,500.00	2,268,500.00	58.1
210604	Урсгал засвар	27,320,000.00	20,456,660.00	6,863,340.00	74.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,007,000.00	63,001,000.00	6,000.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	63,007,000.00	63,001,000.00	6,000.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000,000.00	19,500,000.00	10,500,000.00	65.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,000,000.00	19,000,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,000,000.00	500,000.00	10,500,000.00	4.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	159,555,500.00	148,734,793.33	10,820,706.67	93.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	159,555,500.00	148,734,793.33	10,820,706.67	93.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,015,000.00	15,015,000.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	116,540,500.00	114,753,593.33	1,786,906.67	98.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,000,000.00	18,966,200.00	9,033,800.00	67.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,928,998,369.77	3,228,354,621.98	(299,356,252.21)	110.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,758,998,369.77	2,976,561,083.77	(217,562,714.00)	107.9
132001	Орон нутгийн төсвөөс	2,758,998,369.77	2,976,561,083.77	(217,562,714.00)	107.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	170,000,000.00	251,793,538.21	(81,793,538.21)	148.1
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,000,000.00	40,290,584.00	(10,290,584.00)	134.3
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000,000.00	211,502,954.21	(71,502,954.21)	151.1
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	59.00	59.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	58.00	58.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				
650001	Терийн захиргааны албан хаагч (ТЗ)	24.00	24.00	-	100.0
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	35.00	35.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	168,925,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	168,925,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90,925,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,750,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,750,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,175,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,175,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	78,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	168,925,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	168,925,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	157,425,000.00

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 172,478.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 350.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, алдаа, зөрчлийг арилгах 22,509.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 149,618.9. мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлэв.

. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд буцаан төвлөрүүлсэн санхүүжилтийг тохируулаагүй байна	1	81,793.5					1	81,793.5				
Мөнгөн гүйлгээний тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 733.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна	1	733.3					1	733.3				

Нийслэлийн Архивын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үр дүнгийн тайланд тэтгэмж урамшууллын зардлыг 1,468.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна	1	1,468.7				1	1,468.7				
Нийгмийн даатгалын шимтгэлийн 90.8 төгрөгийн илүү төлөлтийг авлагаар тусгаагүй байна	1	90.8				1	90.8				
Эргэлтийн хөрөнгийг шууд зардлаар бүртгэж тайлагнасан	1	17,575.4				1	17,575.4				
Дүн	5	101,661.7			1	38,500.0	1	101,661.7			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан томилолтоор ажилласан албан хаагчдийн унаа, хоолны мөнгийг давхардуулан олгосон байна	1	350.0	1	350.0				
Дуудлагын 9,428.8 мянган төгрөгийн авто машин унасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажилласан ажлын тайлан нотлох баримт хангалтгүй байна.	1	9,429.8			1	9,429.8		
Бараа материалыг балансын дүнгээс зөрүүтэй тоолж илтгэх хуудас бичсэн байна	1	13,079.4			1	13,079.4		
Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай албан даалгавар хэрэгжиж эхэлсэн хугацаанаас хойш хориглосон ажил гүйлгээг гаргасан байна. / 12 дугаар сарын 16 ны өдөр байгууллагын албан хаагчдад урамшуулал, үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна /	1	130,000.0					1	130,000.0
Урсгал засвар хийсэн ажлын төсөв, тайлан,	1	19,618.9					1	19,618.9

Нийслэлийн Архивын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

нотлох баримт хангалтгүй байна.								
Дүн	5	172,478.1	1	350.0	2	22,509.2	2	149,618.9

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна	1	-					1	-
Дүн	1	-					1	-



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 127 / АУ260 461

Улаанбаатар хот

НААГ-2026/159/НА-СТА-723

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Архивын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн тооллогын илтгэх хуудас нь бараа материалын тооллогын үлдэгдлээс 13,079,400.00 (арван гурван сая далан есөн мянга дөрвөн зуу)-н төгрөгийн зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2. "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1.2-д 4.2.1.2.хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй," заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, зөрүүтэй тайлагнасан зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Архивын газрын дарга Х.Гантулга, нягтлан бодогч П.Оюунгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ

Б.ЦОЛМОН

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090012



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 126/А0260461

Улаанбаатар хот

НТАГ-2025/159/НН-СН-743

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Архивын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын удирдах ажилтан дуудлагын авто машин хэрэглэж 9,428,800.00 (есөн сая дөрвөн зуун хорин найман мянга найман зуу)-н төгрөгийн зардал гаргасныг хангалтгүй, бүрдэл дутуу нотлох баримтыг үндэслэн бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "Хариуцлагатай байх" 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", санхүүгийн тайлагналын " нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11.хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Байгууллагын удирдах ажилтан дуудлагын авто машин хэрэглэсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллаж биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Архивын газрын дарга Х.Гантулга, нягтлан бодогч П.Оюунгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ

Б.ЦОЛМОН

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 дугаар сарын 25

№ 22/А0260/НБ1

Улаанбаатар хот

НТАГ-2025/604/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Архивын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 350,000.00 (гурван зуун тавь) мянган төгрөгийн унаа, хоолны мөнгийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 "Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно" гэж заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8. Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн." гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулан олгосон унаа, хоолны зардал болох 350,000.00 (гурван зуун тавь)-н мянган төгрөгийг Нийслэлийн Архивын газрын төрийн сан дахь МН870090100200051059 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 29-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Архивын газрын дарга Х.Гантулга, нягтлан бодогч П.Оюунгэрэл нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР


Г.НАНДИНЖАРГАЛ
Б.ЦОЛМОН

1424310000